



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/461

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримт боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглах шалгуур үзүүлэлтийн сан бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Д.Бямбасүрэн (Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Батнасан (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Л.Батгэрэл (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

О.Очирбат (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Гэрэлмаа (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

О.Сарангоо (Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн

дарга: О.Олззаяа (Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

8400001 1127

Zah A/461 Kh

2. Бодлого, төлөвлөлтийн бичиг баримт боловсруулах, бодлогын хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн шалгуур үзүүлэлт боловсруулах ажлыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД